

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ  
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** 1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр баталсан Иргэний бүртгэлийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Иргэний улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гэр бүлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагад” гэснийг “улсын бүртгэлийн байгууллагын салбар, нэгж, хилийн чанадад ажиллаж байгаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газарт” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллага” гэснийг “улсын бүртгэлийн байгууллагын салбар, нэгж, хилийн чанадад ажиллаж байгаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар” гэж, 14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсгийн “иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагад” гэснийг “улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний салбар, нэгжид” гэж, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “сум, дүүргийн Засаг дарга, эсхүл иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагын ажилтан” гэснийг “улсын бүртгэлийн байгууллагын улсын бүртгэгч” гэж, 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийн “иргэний гэр бүлийн бүртгэлийн төв байгууллагад” гэснийг “улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Иргэний улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХАРЬЯАТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Харьяатын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“26.2.Монгол Улсын харьяат болсон, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон хүнд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний салбар, нэгж, хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар Монгол Улсын иргэний үнэмлэх олгоно.”

**2 дугаар зүйл.** Харьяатын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, 20.5 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, 20.6 дахь хэсгийн “иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн алба” гэснийг “улсын бүртгэлийн байгууллагын салбар, нэгж” гэж, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “Иргэний бүртгэлийн тухай хуулийн 29.1-д заасан иргэний бүртгэл мэдээллийн сан дахь” гэснийг “Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7.1-д заасан иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Иргэний улсын бүртгэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ХУВИЙН ХЭРГЭЭР ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний салбар, нэгж гадаадад хувийн хэргээр зорчих иргэний энгийн гадаад паспорт авах хүсэлтийг Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цагаачлах хүсэлтийг 30 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.”

**2 дугаар зүйл.** Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, 6 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “нийслэлд иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутагт аймгийн иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн алба” гэснийг “улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний салбар” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Иргэний улсын бүртгэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “Гадаадын иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг нийслэлд иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутагт иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн алба эрхлэн явуулж” гэснийг “Гадаадын иргэнтэй холбоотой иргэний улсын бүртгэлийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний орон нутаг дахь салбар хөтөлж” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Иргэний улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ЦЭРГИЙН ҮҮРГИЙН БОЛОН  
ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН  
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Цэргийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “болон үрчлэлтийн” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Иргэний улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ..дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ДИПЛОМАТ АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Дипломат албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтын “иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг хөтлөх” гэснийг “Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 5.5-д заасан бүртгэлийг хөтлөх” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Иргэний улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

**2016 оны ..дугаар  
сарын ...-ны өдөр**

**Улаанбаатар  
хот**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ  
УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.11 дэх заалтын “түүний шилжилт хөдөлгөөнийг” гэснийг “өрхийн бүртгэлийг” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Иргэний улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ..дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН НУУЦЫН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 17-д заасан “Иргэний бүртгэл, мэдээллийн улсын сан” гэснийг “Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Иргэний улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ..дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн гарчгийн “иргэний” гэсний дараа “улсын” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.5, 10.4.2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Иргэний улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ